# НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 29 өдөр Дугаар А/38 Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Палас ХХК “Зүчи” зочид буудлын 20/30, Молор трейд ХХК-ийн “Тамир” зочид буудлын 20/274, Жамо гранд трэйвел ХХК -

1150500163

ийн “Тэрэлж Хиллс лодж” амралтын газрын 20/194, Сутай тур ХХК -ийн “Ойн жим ” амралтын газрын 20/293 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Х.Содномдэмбэрэл/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА А.АРИУНГЭРЭЛ

5284325 СБТ 8936 1118263502

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2021 оны 07 сарын 29-ны өдрийн А/33 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2021 оны 07 дугаар сарын 29-ны өдөр Улаанбаатар хот

| Д/Д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|---|---|---|---|---|
| 1 | Палас ХХК | 2038528 | Зүчи | ХУД-ийн, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 25а |
| 2 | Молор трейд ХХК | 2571889 | Тамир | БГД-ийн, 13-р хороо,3-р хороолол, Ард Аюушийн өргөн чөлөө 16Б |

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2021 оны 07 сарын 29-ны өдрийн А/30 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2021 оны 07 дугаар сарын 29-ны өдөр Улаанбаатар хот

| Д/Д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|---|---|---|---|---|
| 1 | Бишрэлт гүн ХХК | 2652749 | Бишрэлт гүн | БЗД-ийн, 7-р хороо, Их Тойруу 68 |

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2021 оны 07 сарын 29-ны өдрийн А/38 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2021 оны 07 дугаар сарын 29-ны өдөр Улаанбаатар хот

| Д/Д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|---|---|---|---|---|
| 1 | Жамо гранд трэйвел ХХК | 5861454 | Тэрэлж хилсс лодж | НД-ийн 6-р хороо, Баргын өвөлжөөнд |
| 2 | Сутай тур ХХК | 2703904 | Ойн жим | ЧД-ийн 19-р хороо, Шадивлан зуслан |
| 3 | Араг бургас ХХК | 2008955 | Бүрги эрэг | Багануур дүүрэг 4-р хороо |

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР